

Living the Lotus

5
2021

VOL. 188

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Хоёр үлгэр жишээ

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 188 (2021.05)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Бид ихэнх сургаалыг өөрийн болгосон гэж бодож байсан ч, бодит байдал дээр янз бүрийн асуудалтай тулгарахаар төрөлх зан ааш гарч ирээд, эргээд эгэл жирийн хүн болон хувирч уйлж унжин, сэтгэлээр унах гээд байдаг.

Буддын сургаалын үндэс нь шүтэн барилдлага, өөрөөр хэлбэл нөхцөл шалтгаанаас бүгд үүсэн бий болдог гэсэн сургаал юм. Нөхцөл гэдэг нь учралыг хэлж буй бөгөөд тэрхүү учралыг сайн тийш нь залж чадах эсэх нь бидний сургаалыг хэрэгжүүлж чадаж байгаа эсэхээс хамаарна гэж хэлж болох биз ээ. Түүний жишээ бол ямар ч дургүй хүрэм зүйл, таагүй хүнтэй учирсан өөрийг нь жинхэнэ бурханлаг хүн болгох их багшаа хэмээн хүлээж авдаг “Дэвадаттаг өгүүлэх бүлэг”-ийн сургаал, мөн энэ хүн одоо ямар ч дүр төрхтэй байсан хамаагүй, ирээдүйд гарцаагүй бурханы хутгийг олох хүн байна хэмээн бүх хүнийг нигүүлсэх Ашид Үл Басагч Бодисадвагийн бурханлаг чанарт мөргөх үйл юм.

Ничирэн Хутагт “Бурханы хутаг олох үр” хэмээх үгийг их хэрэглэдэг байсан. Бидний дотор бурханы хутгийг олох үр байдаг ба түүнийг усалж, нар үзүүлж байхгүй бол үр нь нахиалж, ургаж, цэцэглэж чадахгүй. Дээрх ямар ч зүйлийг багшаа гэж хүлээж авах, бүх хүний бурханлаг чанарт мөргөх гэсэн хоёр үлгэр жишээг ямар нэг зүйлтэй учрах бүртээ санаж, түүнийгээ сайны учрал хэмээн хүлээн авч, мөн өөрөө ч гэсэн бусдын сайн учрал нь болохын төлөө хичээн зүтгэснээр жинхэнэ сүсэгтэн хүн болж чадна.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, Х72-73

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Амьдралын агшин бүрт хүндэтгэлтэй хандах

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Ялгахгүй байх

Бид өглөө босоод орой унтах хүртлээ хийж буй үйлдлийнхээ ихэнхийг өөрийн мэдэлгүй чухал, чухал биш гэж ялгаж ангилж амьдардаг биш гэж үү? Судар номоо уншихдаа хайнга хандахгүй мөртлөө гэр бүлтэйгээ мэндлэх тал дээр хайхрамжгүй хандах гэх мэт.

Шоожү (зөв хандлага) настан хэмээн авгайлуулж олонд танигдсан Зэн урсгалын лам Доокёо Этан “Хамгийн чухал зүйл юу вэ гэхээр яг одоогийн сэтгэл тань юм” хэмээн айлдсан байдаг. Өглөө босоод гэр бүлтэйгээ мэндлэх, нүүрээ угаах, түүнийхээ дараагаар судар уншиж, ажил руугаа яван уулзалт хийх гээд бүх л зүйл “хамгаас чухал” байдаг. Тэр бүхэнд яг л адилхан зүрх сэтгэлээ зориулж, нямбай хандах хэрэгтэй гэсэн үг.

Харин тэгж огт чаддаггүй нь зүгээр л завгүй болохоороо бус аливаа зүйлд “ялгаж” ханддаг учраас тэр юм. Угтаа ямар ч зүйлд утга учир, үнэ цэнэ байдаг атал “Энэ бол анхаарах хэрэгтэй зүйл”, “Тэрийг анхаарахгүй байсан ч болно” гэж өөрийнхөө боломжинд тааруулан шийдвэр гаргадаг. Сэтгэл шингээгүй үг, үйлдэл эндээс бий болдог болов уу.

Би урьд өмнө “Цэцгийн гоо үзэсгэлэнд эрэмбэ дараалал гэж үгүй” гэсэн үг сонсож байсан юм. Тэрэн шиг аливаа зүйлийг дуртай, дургүй гэж өнгөц дүгнэх үзлээ хаяад харах юм бол бүгдээрээ л чухал, эрхэм нандин зүйл юм байна хэмээн хүлээж авч чадах болов уу.

Шоожү настны “шоожү” гэдэг нь “зөвөөр хүлээж авах” гэсэн утгатай ба “өөрийн бодлоосоо салж нэг зүйлд төвлөрөх самади” гэдэг үгнээс гаралтай. Тэгэхээр “өнөөдөр яг одоо”-ийн үйлдэлдээ анхаарч төвлөрөхийн тулд дуртай, дургүй гэж ялгах үзлээ хэсэг мартаж чухал юм.

Бусдын төлөө бодох

Дахин өөр өнцгөөс аливаа зүйлд хүндэтгэлтэй хандаж амьдрах тухай бодоод үзье. Жишээ нь манайх хүйтний улиралд ус халаагчаа асааж, халуун ус гарч иртэл крантнаас гоожих хүйтэн усыг тэр чигээр нь урсгаад байлгүй өөр саванд юүлэн агаар чийгшүүлэгчдээ хийх зэргээр ашигладаг. Жаахан усыг ч гэсэн дэмий үрэхгүйн тулд ингэж аргалах нь ч аливаа зүйлд хүндэтгэлтэй хандаж амьдрахтай холбогдох нэгэн жишээ байж магадгүй. Усаар тогтохгүй энгийн үед анзаарч хайхардаггүй зүйлдээ жаахан анхаарал тавиад үзэх юм бол тэдгээр зүйл үнэ цэнэтэй чухал зүйл болж хувирна.

Эсвэл танка, хайкү зэрэг шүлгийн төрлөөс уншиж үзэх нь ч гэсэн өдөр тутмын амьдралын нэгэн агшныг мэдэрч, амьдралынхаа эргэн тойрныг анзаарч харах дасгал болох юм шиг санагдаж байна.

“Залуу навч нахиалахад энэ уулыг хэзээ ч харсан, аль ч модыг нь харсан үзэсгэлэнтэй биш гэж үү.” (Тачибанано Акэби) хэмээх дууны бадаг байдаг. Хаврын улирлыг илэрхийлсэн гэгээлэг дуу бөгөөд энэ мэт дөрвөн улирлын өөрчлөлтийг анзаарч байх нь эгэл жирийн амьдралын аз жаргалыг мэдрүүлж, одоо байгаа энэ цаг хугацаагаа хайрлаж, нандигнах сэтгэлийг бий болгодог.

Гэхдээ зүгээр л “аливаа зүйлд хүндэтгэлтэй хандъя” гэж бодлоо гээд амьдралын дадал зуршил засагдчихна гэсэн үг биш. Тухайн нөхцөл байдалд хийж буй үйл хөдлөл бүрт өөрийн эрхгүй хүндэтгэлтэй ханддаг болохын тулд яах ёстой вэ?

Гайхамшигт ном Цагаан Лянхуа Судрын “Гайхамшигт Эгшигт Бодисадваг өгүүлэх бүлэг”-т Гайхамшигт Эгшигт Бодисадва олон янзын самадыг олдог тухай өгүүлдэг. Тэрхүү самадигийн үндэс сууринд бодисадвагийн хүсэл зорилго агуулагдсан байдаг. “Уулзаж учирсан хүн төдийгүй учраагүй хүмүүсийг ч аз жаргалтай болгоё.”, “Бамбар эргэн тойрноо гэрэлтүүлэх мэт билиг оюуны гэрлээр хүмүүсийг гэрэлтүүлэн гийгүүлнэ” гэсэн зорилгод сэтгэлээ төвлөрүүлэх тийм самадийг олсон гэсэн байдаг. Үүний нэгэн адил ойр орчимдоо байгаа хэн нэгэнд тус болох юмсан, алс холын хэн нэгнийг баярлуулах юмсан гэсэн хүсэл зорилготой байх юм бол нүүрээ угаахдаа хүртэл чамбай хандаж, өөрийн эрхгүй бүх зүйлд ач холбогдол өгч амьдардаг болох болов уу.

Юу ч харсан ямар сайхан юм бэ хэмээн хүлээж авах мэдрэмж төрж байх аваас тэнд үргэлж аз жаргал дүүрэн өдрүүд байдаг юм шүү.

«Косей» 2021 оны 5 сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Гайхамшигт Чимэглэлт Хааны уг явдлыг өгүүлэх 27 дугаар бүлэг

Уг бүлэг нь балар эрт цагт амьдарч байсан Гайхамшигт Чимэглэлт Хаан ба түүний хатан Ариун Эрдэмт, хөвгүүд Ариун Сант, Ариун Нүдэт нарын тухай үлгэр болно.

Гайхамшигт Чимэглэлт хааны түүх

Гайхамшигт Чимэглэлт хааны хатан болон хоёр хүү нь бурханы сургаал шүтдэг байсан ба хаан харин өөр сургаалыг шүтдэг байсан тул тэд яаж ийж байгаад бурханы сургаалын хичнээн талархмаар болохыг хаанд мэдрүүлэхийг хүсч байжээ. Гэтэл санаанд ч үгүй Тэнгэрийн Дуут Одны Ордын Хаан Цэцэглэгч Билигт хэмээх бурхан бээр Цагаан Лянхуа Судар хэмээх оройн дээд сургаалыг айлдаж буйг сонсоод, ханхүү нар заавал хаан ааваа дуудаж сонсохыг туйлаас хүссэн тул хатан эхтэйгээ зөвлөлддөг. Тэгтэл хатан “Аавынхаа сэтгэлийг хөдөлгөхийн тулд та нар гайхамшигийг үзүүлэхээс өөр арга үгүй.” хэмээн санал болгодог.

Тэгээд хоёр хүү нь хаан эцгийнхээ өмнө очин, агаарт нисэн хөөрч, сансар огторгуйгаар алхан, толгой болон хөлийн үзүүрээс ус, гал үлээн гаргаж, газар доогуур чөлөөтэй шумбах зэргээр янз бүрийн гайхамшигийг үзүүлдэг. Хаан аав нь гайхаж, “Ингэхэд хэнээс ийм рид хувилгаан хүчийг сураа вэ?” хэмээн асуухад “Цагаан Лянхуа Судар хэмээх сургаалыг айлдагч Тэнгэрийн Дуут Одны Ордын Хаан Цэцэглэгч Билигт бол бидний багш” гэж хариулдаг. Тэгтэл хаан “Тэр бурхантай би ч гэсэн уулзаж үзмээр байна” гэж хэлдэг. Мэдэж хааны хөвгүүд туйлаас баярлаж, энэ боломжийг алдалгүйгээр сахил хүртэж, үргэлж Бурханы дэргэд зам мөрд суралцахыг хүсч буйгаа хатан ээжээсээ гуйж, түүнийгээ ч зөвшөөрүүлнэ.

Ийнхүү хааны хөвгүүдийн амьдралд тохиолдсон өөрчлөлтөөр хаан, хатан, хааны албатууд болон шивэгчингүүд мөн олон ард иргэд ч Бурхан багшаас сургаал сонсохоор явцгаадаг. Бурхан багш шууд Гайхамшигт Чимэглэлт хаанд “Гарцаагүй бурханы хутгийг олох болно” хэмээх бурханы хутаг олох баталгаа өгдөг. Улмаар хаан эрх мэдлээ дүүдээ шилжүүлээд, хатан болон дагалдагсадынхаа хамтаар сахил хүртдэг байна.



Хувь зохиол бүхнийг шийднэ

Бурханы зам мөрд урт удаан хугацааны турш хичээж шамдсаны эцэст туйлын өндөр түвшинд хүрсэн хаан Бурханд хандан “Миний ийм болсон маань хоёр хүүгийн минь ач билээ” хэмээхэд Бурхан “Тийм шүү. Сайн найз, сайн удирдагчтай учрана гэдэг үнэхээр гайхамшигтай хувь зохиол юм. Тийнхүү сургаалтай учирч, бурханы зам мөрд чиглүүлэх нөхцөл бүрдэж гэмээнэ бурхантай учирч, бурханы билиг оюуныг олох сэтгэл төрдөг билээ.” хэмээн айлддаг.

Үнэхээр “Бурханы сургаалтай учрах хувь зохиол буюу нөхцөл” гэдэг ямар чухал болохыг сайтар бодох хэрэгтэй. Бид ч гэсэн өмнөх насандаа Гайхамшигт номын сургаалыг хэрэгжүүлсэн ба тэр ач буян нь бурханы номтой учрах шалтгаан болж, улмаар энэ насандаа сайн “нөхцөл”-тэй учирснаар одоо ийнхүү Цагаан Лянхуа Судрыг сурч байгаа билээ.

Тиймээс энэ насандаа аль болох олон хүнд Гайхамшигт номын сургаалыг түгээх нь дараа төрөлдөө дахин энэхүү Гайхамшигт номтой учрах хамгийн том баталгаа болох юм. Үүнийг Гайхамшигт Чимэглэлт Хааны уг явдал (хувь зохиол)-аас мэдэж авах нь уг бүлгийн хамгийн гол зорилго юм.

Ойрын хүмүүсээ бурханы зам мөрд хөтлөхийн тулд

Хоёр ханхүүгийн үзүүлсэн гайхамшигт үзэгдэл гэдэг нь бурханы сургаалыг сурч, итгэснээр зан чанараа бүрэн өөрчилж, улмаар өдөр тутмын үйл хэрэг тэс өөр болж өөрчлөгдсөнийг илэрхийлсэн. Түүнийгээ аавдаа үзүүлсэн гэдэг нь бодит үйл хөдлөлөөрөө дамжуулж бурханы сургаалын жинхэнэ үнэ цэнийг батлан харуулж, аавынхаа сэтгэлийг ч эргүүлэн, бурханы зам мөрд замчлан оруулсан гэсэн үг.

Хэн нэгнийг зам мөрд оруулахын тулд сургаалыг тайлбарлаж өгөх нь мэдээж чухал боловч өөрийн биеэр батлан харуулах нь шийдвэрлэх алхам юм. Ялангуяа гэр бүл, ажлын хүндээ сургаал дамжуулахад үүнийг хэрхэвч орхигдуулж болохгүй. Ямар ч сургаал ном айлдсан өөрөө түүнийгээ хэрэгжүүлж, хүмүүсийн сэтгэлийг татдаг байхгүй бол хүмүүс ухаарч ойлгох нь бүү хэл эсрэгээрээ бурханы сургаалыг үл тоомсорлож, итгэхгүй байх магадлалтай. Энэ бүлэгт үүнийг сургасан.

Хөвгүүддээ бодитойгоор баталж харуулахыг санал болгосон хатан ээжийнх нь мэргэн ухаан хийгээд жинхэнэ үнэн (Гайхамшигт номын сургаал)-ийг сонсохыг хүссэн хаан аав нь ч онцгой хүн байсан. Ийм уян хатан сэтгэлтэй хүн л Гайхамшигт номын сургаалыг ухаарч, ойлгож чадна.





Удирдагч хүний итгэл үнэмшил


Өөр нэгэн чухал асуудлыг уг бүлэгт сургасан. Хааны итгэл үнэмшил хааны удмынхан, дагалдагсад болон ард иргэдэд нь хүртэл нөлөөлсөн явдал юм.

Ийм удирдах байр сууринд байгаа хүн зөв итгэл үнэмшилтэй байхад түүний үзүүлэх нөлөө хичнээн их болохыг бодит амьдрал дээр сайтар тунгаан бодох хэрэгтэй.

Итгэл үнэмшил гэдэг угаас хувь хүний эрхийн асуудал бөгөөд улс төр, эрх мэдэлтэй холилдоод ирэхээр бохирдож орхидог. Гэвч нийтэд хүндлэгдсэн удирдагч хүн зөв сүсэг итгэл үнэмшилтэй болсноор олон хүнд сайнаар нөлөөлнө гэдэг нь бохир бус онцгой сайн нөлөө болохыг хэлэхгүй өнгөрч боломгүй. Тиймээс олны дээр байгаа хүн зөв итгэл үнэмшлийг олж авсан байх маш чухал. Мэдээж түүнийгээ доорх хүмүүстээ албадаж тулгаж болохгүй. Зөв сургаалд үндэслэсэн тийм хүний бусдын сайн сайхны төлөө гэсэн хүнлэг сэтгэл, биеэ авч явах байдал олон хүнийг зөв замд оруулах нь дамжиггүй. Энэ ч бас уг бүлгийн нэгэн гол утга санаа билээ.

«Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар»,
Нивано Никкёо, Косей хэвлэлийн компани, 1991 он





Олон улсын хэлтсийн даргын булан

Аз жаргалтай байх үгүйг шийддэг зүйл

Энэ сар Нивано ерөнхийлөгч “өөрийнхөө боломжид тааруулан” шийдвэр гаргахгүй байхыг сануулж, учрал бүрийг утга учиртай чухал зүйл гэж хүлээж авч “агшин бүрт хүндэтгэлтэй хандаж амьдрах”-ыг зөвлөсөн.


Эгэл жирийн хүний сэтгэл үргэлж буруу үзэлд автагдан төөрөлдөж байдаг учраас аливаа зүйлийг “чухал зүйл” гэж шилж сонгохдоо өөрийнхөө хувийн үзэл бодлоор хандаж болохгүй. Энэ бол бурханы үйлийн маш чухал хэсэг гэж хэлж болно. Аз жаргалтай байх үгүй нь өдөр бүр ямар сэтгэлтэй байхаас шалтгаалдаг гэдгийг дахин бодож үзэцгээе.

Косей кай нийгэмлэгийн уламжлалт “Эхлээд бусдын төлөө” хэмээх үйл нь магадгүй ертөнцийн хуулиас гажуудах гээд байдаг бидний бодол сэтгэлийг зөв тийш нь залдаг болов уу.

Мөн “яг одоо, энэ мөч”-д анхаарлаа хандуулах гэсэн утгатай “mindfulness” гэдэг үг байдаг. Ерөнхийлөгчийн сургаалд гарсан “самади” гэдэгтэй ижил утгатай. Өөрийнхөө сэтгэлийн байгаа газар, сэтгэлийн өөрчлөлтөд төвлөрөхөөс гадна өөрт тохиолдож буй хамаг л үйл явдал, учралд “mindfulness” хандлагаар сэтгэлээ төвлөрүүлж чадах юм бол тэндээс аз жаргалын мэдрэмж урган гарч ирж, тэр нь улам бүр тэлэх нь дамжиггүй. Үүнийг бүгдээрээ хамтдаа хэрэгжүүлцгээе.



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>